Техникийн тодорхойлолт

Даланзадгад сумын төвд баригдсан Холбооны барилга нь 1966 онд баригдаж, ашиглалтанд орсон байна. Холбооны барилга нь тэнхлэгээрээ 13х27 хэмжээтэй 3 давхар барилга. Тус барилгын үндсэн хийцлэл: Хана- тоосго, хучилт- мод, дээвэр – шувуу нуруу бүхий төмөр дээвэр

Энэхүү Холбооны барилгад их засвар иж бүрэн хийгдэж байгаагүй. 2002 онд төмөр дээвэрт, 2011 онд дотор засалд хэсэгчлэн засвар хийгдэж байсан байна.

Тус барилгын 1-р давхарын "Үйлчилгээний заал" болон модон ханаар тусгаарлагдсан бусад өрөөнүүдийг нэгтгэн "Аялал жуулчлалын мэдээллийн нэгдсэн төв" байгуулахаар шийдвэрлэгдсэний дагуу ашиглагч байгууллагуудын саналыг үндэслэн архитектор Б.Ганзориг интерьерийн зургийг боловсруулж, Аймгийн ерөнхий архитектор Ц.Золбоо баталжээ.

Энэхүү интерьерийн зураг төслийг үндэслэн засварын ажлын төсвийн тооцоог гүйцэтгэлээ.

Буулгах ажлууд: 1-р давхарын Үйлчилгээний заалны голын даацын хана, баганаас бусад модон хана, хаалтуудыг бүгдийг буулгана.

Одоо байгаа дүүжин тааз, Нийт 9 цонх болон цонхны тавцан, явган доторлогоо, модон шалуудыг буулгана.

Засварын ажлыг гүйцэтгэхдээ тус интерьерийн зурагт тусгагдсан материал хийц эдлэлээр, барилгын холбогдох норм дүрэм, стандартыг баримтлан чанартай гүйцэтгэх шаардлагатай.

"Аялал жуулчлалын мэдээллийн нэгдсэн төв" болон "Coffee shop"-ийн зориулалтаар ашиглагдах заалнуудыг уналттай дүүжин тааз тай байхаар төлөвлөсөн.

Даацын багана, дам нуруу, зарим ханууд ын заслалыг сүүлийн үед гарч буй доторлогоо, өнгөлгөөний материалуудыг оролцуулан засварлахаар төсвийн тооцоонд тусгасан.

Засварын ажилд шаардагдах бусад ажлуудыг засварын төсвийн тооцоонд тусгагдсан ажлын тоо хэмжээний хүрээнд чанартай гүйцэтгэнэ

Төсвийн тооцоонд тусгагдсан " Аялал жуулчлалын мэдээллийн төв"-д шаардлагатай "Лого бүхий гэрлэн самбар, мөн заалны үйлчилгээнд ашиглагдах ширээ-6ш, сандал№12ш, тек- 2ш, "Coffee shop"-ийн номын тавиур бүхий модон хана зэргийг интерьерийн зурагт тусгагдсаны дагуу болон техникийн тодорхойлолтын хавсралтанд заасаны дагуу чанар стандартын шаардлагад нийцүүлэн нийлүүлнэ.

Зөвлөмж: Төсөвт тусгагдсан засварын ажил болон тохижилтын ажлыг гүйцэтгэхдээ чанар стандартын шаардлага хангасан материалаар гүйцэтгэх болон бараг нийлүүлэх шаардлагатай. Барилгын засварын ажилд хэрэглэгдэх гол гол материалууд болон бараг чанар стандартын шаардлага хангаж буй эсэхийг захиалагч, зохиогчид үзүүлж, зөвшөөрсөний үндсэн дээр засварын болон тохижилтын ажилд ашиглах хэрэгтэй.Тус барилгын засварын ажлыг гүйцэтгэх явцдаа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай", "Барилгын тухай" хуулиуд болон Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны чиглэлээр гарсан БНбД12-01-03, БНбД12-03-04, БНбД12-04-06, БД12-101-05 –ийг чанд мөрдөж, хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй